

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ШШГЕГ-ын харьяа 433 дугаар хаалттай хорих ангийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/019-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn www.open.audit.mn Сүхбаатар сум 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: О.Анхбаяр Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Албан шаардлага	19
5.2 Зөвлөмж	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газар
ХЗДХ	Хууль зүй дотоод хэргийн яам
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ШШГЕГ-ЫН ХАРЬЯА 433 ДУГААР
ХААЛТТАЙ ХОРИХ АНГИЙН ДАРГА,
ХУРАНДАА Л.ЭРДЭНЭБАТ ТАНАА

2025.02.14 № ОА-2025/019-НА-ОА-ТМБ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ШШГЕГ-ын харьяа 433 дугаар хаалттай хорих ангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ШШГЕГ-ын харьяа 433 дугаар хаалттай хорих ангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд ШШГЕГ, Хорих ял эдлүүлэх алба, ХЗДХ-ын яам, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ зэрэг байгууллагуудаас **782,290.4** мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч хөрөнгөд бүртгэсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн 100130412402 тоот дансанд ШШГЕГ-аас 46,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус газрын тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн сар бүр өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн

4325027273

төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Бусад асуудлын хэсэг

ШШГЕГ-ын харьяа 433 дугаар хаалттай хорих анги нь тайлант онд “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	505,835,622.78	578,043,826.92
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	18,623,373.37	19,297,920.86
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	18,623,373.37	19,297,920.86
31210	Төгрөг	18,623,373.37	19,297,920.86
31211	Төрийн сангийн харилцах	18,623,373.37	19,297,920.86
33	АВЛАГА	0.00	15,000,000.18
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	0.18
33500	Бусад авлага	0.00	15,000,000.00
33510	Байгууллагаас авах авлага	0.00	15,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	487,212,249.41	543,745,905.88
35100	Түүхий эд материал	21,968,709.66	26,843,996.94
35110	Тусгай зориулалттай материал	18,715,848.00	24,081,718.00
35130	Эм боох материал	3,252,861.66	2,762,278.94
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	7,992,396.97	19,902,498.45
35300	Бэлэн бүтээгдэхүүн	45,973,281.97	61,918,653.48
35400	Хангамжийн материал	181,042,860.81	209,610,757.01
35410	Бичиг хэргийн материал	1,122,400.00	653,300.00
35420	Аж ахуйн материал	50,046,142.70	36,741,524.54
35440	Түлш, шатах тослох материал	19,768,636.35	28,462,007.44
35450	Барилгын засварын материал	50,006,443.68	55,300,499.79
35460	Хүнсний материал	37,426,798.87	65,867,842.86
35470	Бусад хангамжийн материал	21,701,439.21	22,585,582.38
35600	Мал амьтад	230,235,000.00	225,470,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,497,977,108.87	7,237,414,398.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,497,977,108.87	7,237,414,398.86
39200	Биет хөрөнгө	1,418,037,191.88	2,157,787,481.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,356,626,444.92	1,474,483,540.92
39202	Хуримтлагдсан элэгдэл	-661,463,962.11	-742,629,037.03
39203	Авто-тээврийн хэрэгсэл	439,906,150.00	919,562,990.14
39204	Хуримтлагдсан элэгдэл	-344,882,815.98	-142,503,332.90
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	716,495,153.01	730,861,363.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	-199,709,168.20	-218,172,074.46
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,947,212.00	66,358,732.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,127,820.11	-19,007,200.85
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	15,463,660.00	15,463,660.00
39216	Дуусаагүй барилга, байгууламж	49,122,075.00	73,368,841.00
39300	Биет бус хөрөнгө	5,079,939,916.99	5,079,626,917.03
39301	Программ хангамж	4,437,692.31	4,437,692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,837,775.32	-4,150,775.28
39303	Бусад биет бус хөрөнгө	5,079,340,000.00	5,079,340,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,003,812,731.65	7,815,458,225.78
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	19,002,886.59	23,585,786.85
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19,002,886.59	23,585,786.85
41300	Өглөг	19,002,886.59	23,585,786.85
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,970,056.53	5,048.70
41360	Бусад өглөг	17,032,830.06	23,580,738.15
41361	Байгууллагад төлөх өглөг	16,020,000.00	7,359,297.61
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,012,830.06	16,221,440.54

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,984,809,845.06	7,791,872,438.93
51	Засгийн газрын хувь оролцоо	6,984,809,845.06	7,791,872,438.93
51100	Засгийн газрын оруулсан капитал	5,354,710,670.66	5,354,710,670.66
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	5,354,710,670.66	5,354,710,670.66
51200	Хуримтлагдсан үр дүн	751,322,034.43	1,558,384,628.30
51210	Өмнөх үеийн үр дүн	885,397,106.62	751,322,034.43
51220	Тайлант үеийн үр дүн	-134,075,072.19	807,062,593.87
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	878,777,139.97	878,777,139.97
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,003,812,731.65	7,815,458,225.78

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,311,570,115.83	5,459,896,998.23
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	585,601,915.83	1,464,766,098.23
120	Нийтлэг татварын бус орлого	585,601,915.83	1,464,766,098.23
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	566,890,927.03	1,462,110,198.23
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	472,272,551.03	465,549,852.09
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	94,618,376.00	996,560,346.14
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	18,710,988.80	2,655,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,725,968,200.00	3,995,130,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,685,968,200.00	3,949,130,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,685,968,200.00	3,949,130,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,000,000.00	46,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,000,000.00	46,000,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,445,645,188.02	4,652,834,403.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,445,645,188.02	4,652,834,403.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,322,459,488.02	4,162,518,903.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,847,048,635.94	2,593,172,831.92
210101	Үндсэн цалин	1,195,463,652.87	1,323,986,122.59
210102	Нэмэгдэл	611,677,983.07	1,243,186,709.33
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,750,500.00	0.00
210104	Урамшуулал	29,156,500.00	26,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,405,532.82	57,098,113.04
210201	Тэтгэврийн даатгал	2,960,089.57	319,313.04
210202	Тэтгэмжийн даатгал	348,245.83	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	288,520.67	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	69,649.18	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	31,739,027.57	56,778,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	252,563,873.72	276,023,478.00
210301	Гэрэл, цахилгаан	146,489,108.23	148,318,000.00
210302	Түлш, халаалт	106,074,765.49	126,811,378.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	894,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	363,914,632.01	353,396,539.85
210401	Бичиг хэрэг	7,212,602.00	10,353,650.00
210402	Тээвэр, шатахуун	66,763,679.00	85,399,829.94
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,448,634.00	5,085,800.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	146,000.00	700,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,187,058.90	20,489,250.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	250,171,651.16	207,491,631.72
210408	Бараа материал асгалсны зардал	29,985,006.95	23,876,378.19
2105	Нормативт зардал	397,466,621.25	483,215,106.35
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,442,612.91	24,367,382.72
210502	Хоол, хүнс	368,869,285.84	426,202,637.73
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,154,722.50	32,645,085.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	201,176,619.52	143,250,502.40
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,687,200.00	3,022,200.00
210604	Урсгал засвар	196,489,419.52	140,228,302.40
2107	Томилолт, зочны зардал	2,465,400.00	500,000.00
210702	Дотоод албан томилолт	2,465,400.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,618,785.05	15,895,710.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,492,800.05	8,417,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	467,900.00	306,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	324,100.00	505,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	180,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,488,600.00	4,468,200.00
210807	Газрын төлбөр	1,665,385.00	2,198,710.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	210,799,387.71	239,966,622.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,672,388.88	23,956,199.65
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	431,800.00	1,090,350.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	191,695,198.83	214,920,072.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,123,185,700.00	490,315,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,068,160,200.00	435,315,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	232,671,800.00	212,044,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	823,072,600.00	205,239,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,415,800.00	18,031,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	500.00	200.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	500.00	200.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	55,025,000.00	55,000,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,025,000.00	55,000,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-134,075,072.19	807,062,594.63
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	0.76
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	0.76
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-134,075,072.19	807,062,593.87

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,183,132,310.77	4,564,304,380.23
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	457,164,110.77	569,173,480.23
120	Нийтлэг татварын бус орлого	457,164,110.77	569,173,480.23
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	434,178,167.46	568,976,543.22

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	115,165,700.00	362,026,843.22
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	319,012,467.46	206,949,700.00
120009	Бусад орлого	22,985,943.31	196,937.01
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,725,968,200.00	3,995,130,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,685,968,200.00	3,949,130,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,685,968,200.00	3,949,130,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,000,000.00	46,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,000,000.00	46,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,161,746,468.40	4,544,713,032.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,161,746,468.40	4,544,713,032.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,075,210,768.40	4,045,636,830.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,863,178,100.00	2,595,559,000.00
210101	Үндсэн цалин	1,194,811,917.32	1,429,192,000.00
210102	Нэмэгдэл	628,487,347.42	1,140,367,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,722,335.26	0.00
210104	Урамшуулал	29,156,500.00	26,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,137,100.00	56,773,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	40,137,100.00	56,773,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	262,873,900.00	288,647,000.00
210301	Гэрэл, цахилгаан	155,355,600.00	148,318,000.00
210302	Түлш, халаалт	107,518,300.00	139,434,900.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	894,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	119,643,900.00	145,585,900.00
210401	Бичиг хэрэг	7,102,200.00	9,004,800.00
210402	Тээвэр, шатахуун	99,709,400.00	121,888,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,504,200.00	5,085,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	146,000.00	700,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,182,100.00	8,906,700.00
2105	Нормативт зардал	392,158,900.00	466,241,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,943,100.00	23,741,800.00
210502	Хоол, хүнс	377,215,800.00	442,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	170,971,300.00	157,751,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,470,000.00	2,031,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,077,400.00	4,134,000.00
210604	Урсгал засвар	153,423,900.00	151,586,100.00
2107	Томилолт, зочны зардал	2,465,400.00	500,000.00
210702	Дотоод албан томилолт	2,465,400.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	163,295,268.40	146,254,330.35
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	156,016,468.40	138,775,530.35
210803	Даатгалын үйлчилгээ	467,900.00	306,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	324,100.00	505,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	180,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,488,600.00	4,468,200.00
210807	Газрын төлбөр	1,818,200.00	2,198,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,486,900.00	188,323,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	59,850,000.00	187,229,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	636,900.00	1,094,100.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,086,535,700.00	499,076,202.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,067,735,200.00	435,315,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	232,671,800.00	212,044,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	823,072,600.00	205,239,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,990,800.00	18,031,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	500.00	200.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	500.00	200.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,800,000.00	63,760,702.39
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,800,000.00	63,760,702.39
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	21,385,842.37	19,591,347.49
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	6,530,000.00	18,916,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,530,000.00	18,916,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,530,000.00	18,916,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,530,000.00	18,916,800.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-6,530,000.00	-18,916,800.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	14,855,842.37	674,547.49
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,767,531.00	18,623,373.37
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,623,373.37	19,297,920.86

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,354,710,670.66	878,777,139.97	885,396,376.62	7,118,884,187.25
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	730.00	730.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,354,710,670.66	878,777,139.97	885,397,106.62	7,118,884,917.25
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-134,075,072.19	-134,075,072.19
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,354,710,670.66	878,777,139.97	751,322,034.43	6,984,809,845.06
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,354,710,670.66	878,777,139.97	751,322,034.43	6,984,809,845.06
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,354,710,670.66	878,777,139.97	751,322,034.43	6,984,809,845.06
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	807,062,593.87	807,062,593.87

20	2024 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	5,354,710,670.66	878,777,139.97	1,558,384,628.30	7,791,872,438.93
----	--------------------------------------	------------------	----------------	------------------	------------------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү /хэтрэлт, хэмнэлт/	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,330,100,400.00	4,330,100,400.00	0.00	100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,330,100,400.00	4,330,100,400.00	0.00	100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,909,516,100.00	3,909,516,100.00	0.00	100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,595,559,000.00	2,595,559,000.00	0.00	100.00
210101	Үндсэн цалин	1,429,192,000.00	1,429,192,000.00	0.00	100.00
210102	Нэмэгдэл	1,140,367,000.00	1,140,367,000.00	0.00	100.00
210104	Урамшуулал	26,000,000.00	26,000,000.00	0.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,773,800.00	56,773,800.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	56,773,800.00	56,773,800.00	0.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	288,647,000.00	288,647,000.00	0.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	148,318,000.00	148,318,000.00	0.00	100.00
210302	Түлш, халаалт	139,434,900.00	139,434,900.00	0.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	894,100.00	894,100.00	0.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	145,585,900.00	145,585,900.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	9,004,800.00	9,004,800.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	121,888,600.00	121,888,600.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,085,800.00	5,085,800.00	0.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700,000.00	700,000.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,906,700.00	8,906,700.00	0.00	100.00
2105	Нормативт зардал	466,241,800.00	466,241,800.00	0.00	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,741,800.00	23,741,800.00	0.00	100.00
210502	Хоол, хүнс	442,500,000.00	442,500,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	142,168,100.00	142,168,100.00	0.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,948,000.00	20,948,000.00	0.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,134,000.00	4,134,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	117,086,100.00	117,086,100.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	500,000.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	500,000.00	500,000.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,716,800.00	33,716,800.00	0.00	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,238,000.00	26,238,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	306,400.00	306,400.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	505,400.00	505,400.00	0.00	100.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,468,200.00	4,468,200.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	2,198,800.00	2,198,800.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	180,323,700.00	180,323,700.00	0.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	179,229,600.00	179,229,600.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,094,100.00	1,094,100.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	420,584,300.00	420,584,300.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	420,584,300.00	420,584,300.00	0.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	212,044,400.00	212,044,400.00	0.00	100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	205,239,900.00	205,239,900.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,300,000.00	3,300,000.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,330,100,400.00	4,330,100,400.00	0.00	100.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,949,130,900.00	3,949,130,900.00	0.00	100.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	3,949,130,900.00	3,949,130,900.00	0.00	100.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	380,969,500.00	380,969,500.00	0.00	100.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	174,019,800.00	174,019,800.00	0.00	100.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	206,949,700.00	206,949,700.00	0.00	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар / цаашид ШШГЕГ гэх/-ын харьяа 433 дугаар хаалттай хорих анги нь “Байгууллагын соёлыг төлөвшүүлж, ахлагчийн манлайллыг дэмжих” гэсэн зорилго тавин ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлон хэрэгжүүлж, ажилласан байна. Үүнд:

- Хорих ялыг албадан эдлүүлэх,
- Хоригдлын аюулгүй байдлыг хангах, тэдний дунд хууль ёс, дэг журмыг сахиулах, хоригдол бусад этгээдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх,
- Хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх,
- Хоригдлыг хөдөлмөрлүүлэх, эрхэлсэн үйлдвэрлэлийн чиглэлээр хоригдолд дадлага олгох,
- Хоригдлын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах,
- Бусдын эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй халдварт өвчтэй, согтуурах, мансуурах донтох эмгэгтэй хоригдлыг албадан эмчлэх,

- *Гэмт хэргийн улмаас хүн, хуулийн этгээдэд учруулсан хохирол, төлбөрийг хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс суутгаж шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст шилжүүлэх, хорих байгууллагад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх,*
- *Хуульд заасан бусад чиг үүрэг.*

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дугаар сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлт тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 01 дүгээр сарын 17, 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд тус хаалттай хорих ангийн санхүүгийн үйл ажиллагаанд ШШГЕГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс 1 удаагийн хяналт, шалгалт хийж заавар зөвлөмж өгсөн байна. Мөн сар бүр шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, төсвийн гүйцэтгэл болон байгууллагын харилцах дансны гүйлгээнд хяналт тавьж, үүрэг чиглэл өгч ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ШШГЕГ-ын харьяа 433 дугаар хаалттай хорих ангийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг **аккруэл** сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус хаалттай хорих анги нь ШШГЕГ-ын даргын 2020 оны А/134 дүгээр тушаалаар баталсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нягтлан бодох

бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

ШШГЕГ-ын харьяа 433 дугаар хаалттай хорих ангийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 811,645.5 мянган төгрөгөөр буюу 11.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	18,623.4	19,297.9	674.5
Авлага	0.0	15,000.0	15,000.0
Бараа материал	487,212.2	543,745.9	56,533.7
Үндсэн хөрөнгө	6,497,977.1	7,237,414.4	739,437.3
Нийт хөрөнгө	7,003,812.7	7,815,458.2	811,645.5
Өр төлбөр	19,002.9	23,585.8	4,582.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,984,809.8	7,791,872.4	807,062.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	7,003,812.7	7,815,458.2	811,645.5

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

Авлага данс 15,000.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь ШШГЕГ-т төмс борлуулсан дүнгээр байгууллагаас авах авлага үүсгэсэн буюу дотоод тооцооны авлагаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 543,745.9 мянган төгрөг болж 56,533.7 мянган төгрөгөөр өссөн нь дараах хүчин зүйлүүдээс голлон шалтгаалсан байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 1,090,589.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан,
- ШШГЕГ, Хорих ял эдлүүлэх албанаас 39,755.7 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авсан,
- Үйлдвэрлэлийн төлөвлөгөөний дагуу 311,485.5 мянган төгрөгийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн,
- Иргэн, байгууллагад 173,500.4 мянган төгрөгийн бэлэн бүтээгдэхүүнийг худалдан борлуулсан,
- Үйл ажиллагаа, үйлдвэрлэлд 1,269,119.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан гэх мэт.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,237,414.4 мянган төгрөг болж 739,437.3 мянган төгрөгөөр өссөн нь ШШГЕГ, Хорих ял эдлүүлэх алба, ХЗДХ-ийн яам, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ зэрэг байгууллагуудаас 782,290.4 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй авсан, ТӨБЗГ-ын шийдвэрээр 338,357.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, устгасан зэргээс голлон шалтгаалсан байна.

Өр төлбөр данс 23,585.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдаж, өмнөх оноос 4,582.9 мянган төгрөгөөр өссөн нь хоригдлын нэрийн дансны үлдэгдлээр хувь хүнд төлөх өглөг үүсгэснээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,476,507.1 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 1,020,883.8 мянган төгрөг, нийт зардлыг 5,497,390.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 1,804,781.5 мянган төгрөгөөр бууруулж, нийт 3,692,609.4 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 266,368.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 2,949.9 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 93,909.4 мянган төгрөгөөр,
- Хангамж бараа материалын зардлыг 19,884.6 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 180,407.3 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 1,120,128.5 мянган төгрөгөөр,
- Томилот, зочны зардлыг 7,934.0 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 35,381.6 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 417,758.2 мянган төгрөгөөр,
- Бусад урсгал шилжүүлгийн зардлыг 192,796.9 мянган төгрөгөөр зэрэг.

Төсвийн жилийн дундуур батлагдсан төсвийг 637,491.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн /цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 121,606.90 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 20,402.4 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 84,772.6 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 418,604.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлсөн байна/ нийт **4,330,100.4** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Улсын төсвөөс 3,949,130.9 мянган төгрөг,
- Үндсэн үйл ажиллагааны орлогоос 174,019.8 мянган төгрөг
- Туслах үйл ажиллагааны орлогоос 206,949.7 мянган төгрөг гэх мэт.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлээр төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,949,130.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 174,019.8 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 206,949.7 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,949,130.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 174,019.8 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоор 206,949.7 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,330,100.4 мянган төгрөг буюу 100.0 хувьтай тайлагнагдсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

					/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	3,662,566.4	3,662,566.4	0.0	100.0	
2	Туслах үйл ажиллагааны зардал	246,949.7	246,949.7	0.0	100.0	
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	420,584.3	420,584.3	0.0	100.0	
	Дүн	4,330,100.4	4,330,100.4	0.0	100.0	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус хаалттай хорих ангийн нэмэлт санхүүжилтийн дансанд ШШГЕГ-аас төсөл, арга хэмжээний санхүүжилт 46,000.0 мянган төгрөг төвлөрснийг 400 хоригдлын байрны бие засах газрын засвар хийх, ШШГЕГ-д 8 ханатай, сийлбэртэй, иж бүрэн тавилгатай гэр хийж өгөх ажлуудад зориулалтын дагуу зарцуулсан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

					/мянган төгрөгөөр/	
№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам /Тендер шалгаруулалтын арга/		
1	Хүнсний материал /Мах, махан бүтээгдэхүүн – 153,326.7 мянган төгрөг/	479,000.0		НТШ		
2	Хүнсний материал /Хуурай хүнс, ногоо – 185,148.3 мянган төгрөг/					
3	Хүнсний материал /Гурил – 140,525.0 мянган төгрөг/					

4	Нүүрс	107,500.0	107,500.0	НТШ
5	Шатахуун, шатах тослох материал	99,709.4	99,709.4	НТШ
	Нийт дүн	686,209.4	252,095.0	

Хоол, хүнсний материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг 10 удаа зохион байгуулсан боловч оролцогч ирээгүй тул тендер шалгаруулалтын аргыг өөрчлөн харьцуулалтын аргаар зарлахад дахин оролцогч ирээгүй байна. Иймд өмнөх онуудад гэрээний үндсэн дээр бэлтгэн нийлүүлэлт хийж байсан Ноцох дөл ХХК, Тулгат сэндэр ХХК, Хараамонгилмаа ХХК, Уужимхараа ХХК зэрэг байгууллагуудтай гэрээ байгуулан хоол, хүнсний материалын худалдан авалтыг гүйцэтгэсэн байна. Нүүрс нийлүүлэх тендерт Монничкон трейд, шатахуун, шатах тослох материалын тендерт Сод монгол групп ХХК тус тус шалгарч гэрээ байгуулан, худалдан авах ажиллагааг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу ШШГЕГ-ын харьяа 433 дугаар хаалттай хорих ангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн цалингийн бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

ШШГЕГ-ын харьяа 433 дугаар хаалттай хорих ангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/57 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,445,645.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу **44,456.4** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж дүгнэсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ШШГЕГ-ын харьяа 433 дугаар хаалттай хорих анги нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Алба хаагч, хоригдлын хоол хүнсний материалыг тухайн сард нь баталсан төсөвт багтаан худалдан авалтыг зохион байгуулж илчлэг, чанартай хоол хүнсээр ханган, хүнсний төсөв, зардлыг хэмнэх зорилгоор адуу 7 толгой, үхэр 20 толгой, хонь 55 толгой, ямаа 29 толгой нийт 27 толгой бод, 84 толгой боз малыг нядалж, мах 2462.7 кг, дотор гэдэс 547 кг, нийт 3009.7 кг мах, махан бүтээгдэхүүнийг бэлтгэн махны хэрэгцээний тодорхой хувийг хангасан,
- 2024 онд дотоод орлого бүрдүүлэх, ангийн хүнсний ногооны хэрэгцээг хангах зорилгоор 31 га газарт төмс хүнсний ногоо тариалан байцаа 28 тонн, төмс 210 тонн, манжин 26 тонн, лууван 53 тонн хураан авч ШШГЕГ-ын төвлөрсөн хангалтад 106 тонн хүнсний ногоог нийлүүлж, дотоод орлогын төлөвлөгөөг 100 хувь биелүүлсэн. Мөн ангийн хүнсний ногооны хэрэгцээ болон намрын тариалалтын төмсний үрийн хэрэгцээг дотооддоо бүрэн хангаж, нөөцийг бий болгосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд ШШГЕГ-ын харьяа 433 дугаар хаалттай хорих анги нь мэдээлбэл зохих 29 төрлийн 169 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	1,907.1	1	1,907.1	100.0
Зөвлөмж	2	24,041.9	2	24,041.9	100.0
Нийт дүн	3	25,949.0	3	25,949.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. ШШГЕГ-ын харьяа 433 дугаар хаалттай хорих ангийн төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

- ШШГЕГ-ын 2024 оны 06/1193 тоот албан бичгийн дагуу хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлаас **20,524.0** мянган төгрөгийн ХХОАТ суутгасан байна.
- ШШГЕГ-ын даргын 2024 оны Б/469, Б/880, Б/966 дугаар тушаал, Б/1050, 05/1570 дугаар бүхий албан бичгүүдээр өгсөн чиглэлийн дагуу цалин, урамшууллын батлагдсан төсвөөс нийт 9 албан хаагчид **9,043.2** мянган төгрөгийн нэг удаагийн шинжтэй шагналын зардал гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг зөрчсөн байна.
- Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн системээр төсвийн төлөвлөлтийг хийж гүйцэтгэдэг атал ХЗДХ-ийн сайдын 2022 оны А/128 дугаар тушаал, Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 3/2881 дүгээр албан бичгийг үндэслэн хөрөнгөд бүртгэлгүй төсвийн төлөвлөлтийн программын үйлчилгээний төлбөр, хөгжүүлэлтэд 4,000.0 мянган төгрөгийг “Даталанд технологи” ХХК-д шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2. Тайлант оны эцэст тусгай зориулалтын материал, бэлэн бүтээгдэхүүн, түлш, шатах тослох материал, хүнсний материал зэрэг бараа материал ихээхэн хэмжээний үлдэгдэлтэй буюу өмнөх оноос 1.3-1.7 дахин өссөн дүнтэй тайлагнагдсан бөгөөд эдгээр бараа материалын хадгалалт, хамгаалалт, ашиглалт, зарцуулалтыг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой нийт 27,845.6 мянган төгрөгийн алдаа илэрч аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Бараа материалын дуусаагүй үйлдвэрлэл дансны үлдэгдлийг 27,845.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,

Аудитаар **6,867.0** мянган төгрөгийн зөрчил¹ илэрч 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

5.1 Албан шаардлага

1. Батлагдсан төсвийг зориулалт бусаар, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, бодитоор тайлагнаагүй **6,867.0** мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэж заасныг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврын*”-ыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- Бараа үйлчилгээний бусад зардлаас урсгал засварын материал худалдан авахад 3,107.0 мянган төгрөг,
- Цалингийн зардлын батлагдсан төсвөөс нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшууллын зардалд 3,760.0 мянган төгрөг гэх мэт.

Шийдвэрлэлт: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын бүртгэлтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Үйлдвэрийн ажилчдын цалинг бодож, олгохдоо НДШ, ХХОАТ-ыг давхардуулан суутгаж, шилжүүлсэн нь өр төлбөр, авлага үүсгэх эрсдэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: 2025 оны эхний хагас жилд багтаан татвар, нийгмийн даатгалын байгууллагатай тооцоо нийлж, өр төлбөр, авлагын үлдэгдлийг баталгаажуулан, барагдуулах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дуусаагүй үйлдвэрлэл дансны үлдэгдлийг илүү тайлагнасан	1	27,845.6			1	27,845.6	1	27,845.6				
Дүн	1	27,845.6			1	27,845.6	1	27,845.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийг зориулалт бусаар зарцуулсан	1	6,867.0			1	6,867.0						
НДШ, ХХОАТ-ын суутгалыг давхардуулсан	1						1					
Дүн	1	6,867.0			1	6,867.0	1					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн